



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

Хөрөнгө хүлээн авч бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэн Л. Дэлгэрбатаас төрд учруулсан хохиролд тооцон шилжүүлэх хүсэлт гаргасан Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороо 5 дугаар хороолол Сайн ноён хан Намнансүрэнгийн гудамж 38 дугаар байрны 30,31 тоот хаягт байрлах нийт 269,669,721.00 (хоёр зуун жаран есөн сая зургаан зуун жаран есөн мянга долоон зуун хорин нэгэн) төгрөгийн үнэлгээтэй 105.51 м.кв талбай бүхий нийт 4 өрөө орон сууцыг төрийн өмчид хүлээн авч “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлэн, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.”Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрд учруулсан хохиролд тооцон шилжүүлэх Иргэн Л. Дэлгэрбатын хүсэлтийг үндэслэн орон сууцны өмчлөх эрх шилжүүлэх гэрээ байгуулах;

2.2. Холбогдох баримтыг бүрдүүлэн Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандаж орон сууцны өмчлөх эрхийг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр бүртгүүлэх;

2.3. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.4. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Наангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НААНГЭРЭЛ

132001308
\Huraldaanii material\2021 он\2021.05.11\huraldaan.docx